



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 07 сарын 09 өдөр

Дугаар А/345

Чингис хот

Зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 2021 оны Төсвийн тухай хуулийн XV.2.1.3, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.1, 11.2.5 дахь заалтууд, Засгийн газрын 2014 оны 222 дугаар тогтоолоор баталсан “Авто зам, төмөр замын салбарт хэрэгжүүлэх зарим төсөл, хөтөлбөрт шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах тусгай журам”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Биндэр сумын Онон голын төмөр бетон гүүр барих ажилд зориулан тус сумын нутгаас түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах зөвшөөрлийг “Гангүүр” ХХК-д ажил гүйцэтгэх гэрээний хугацаа дуусах хүртэл хугацаанд олгосугай.


2. Гүүрийн барилга угсралтын ажилд шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах газрын байршил, тоо хэмжээг хавсралтаар баталсугай.

3. Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийг орон нутгийн төсөвт төлөх, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх төлөвлөгөөг батлуулах, ашиглалтын дараа техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийж сумын Засаг даргын захирамжаар батлагдсан ажлын хэсэгт актаар хүлээлгэн өгөхийг “Гангүүр” ХХК-д үүрэг болгосугай.

4. Зөвшөөрөл олгосон газрын үйл ажиллагаанд хууль, журмын хүрээнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Мэргэжлийн хяналтын газар (Б.Сүнгээ), Байгаль орчин, аялал жуулчлалын газар (Б.Дархантөр), Татварын хэлтэс (А.Гантөмөр), Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар (Д.Баярхүү), түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглуулах гэрээ байгуулж, хэрэгжилтийг дүгнэж ажиллахыг Биндэр сумын Засаг дарга (Э.Мөнх-Очир) нарт үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Э.Мөнх-Эрдэнэ)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

07 Аймгийн Засаг даргын 2021 оны
 дугаар сарын 09 Өдрийн А/345
 дугаар захирамжийн хавсралт

БИНДЭР СУМЫН ОНОН ГОЛЫН ТӨМӨРБЕТОН ГҮҮРИЙН БАРИЛГА УГСРАЛТЫН
 АЖИЛД ШААРДАГДАХ ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛ АШИГЛАХ
 ГАЗРЫН БАЙРШИЛ, ТОО ХЭМЖЭЭ

№	Газрын нэр	Зориулалт	Координат		Ашиглах хэмжээ м ³
			Өргөрөг	Уртраг	
1	Өвгөн сансарын ар	Далангийн дүүргэлт	E 110° 40' 27.00"	N 48° 36' 47.40"	3406.0
	1		110°35'51.20"	48°36'24.50"	
	2		110°35'57/30"	48°36'21/00"	
	3		110°35'50.90"	48°36'18/30"	
	4		110°35'48.10"	48°36'21.80"	
2	Сүлжээгийн хойд эрэгцэг	Далангийн дүүргэлт	E 110° 32' 05.70"	N 48° 49' 32.80"	27000.0
	1		110°40'20.70"	48°36'40.70"	
	2		110°40'18.00"	48°36'45.50"	
	3		110°40'25.10"	48°36'46.90"	
	4		110°40'27.10'	48°36'43.80"	
3	Хонин толгойн ар	Чулуу	E 110° 39' 31.70"	N 48° 33' 21.70"	778.0
	1		110°39'29.60"	48°33'22.00"	
	2		110°39'35.00"	48°33'21.50"	
	3		110°39'34.00"	48°33'16.10"	
	4		110°39'25.50"	48°33'17.00"	